



# АЛТАН ГАДАС ОДОНТ “ХОРИНХОЁР ДУГААР БААЗ” ХК

2020 оны 05 сарын 28 өдөр

№ 6

Улаанбаатар хот

## “22-р БААЗ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Хорин хоёрдугаар” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит бус хурал 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Энх тайвны өргөн чөлөө өөрийн байранд болов.

Хуралд :

- Монгол секюритиес ҮЦК ХК 380940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
- Т.Эрдэнэбаатар 89020 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Л.Гүндэгмаа 18808 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- З.Номундарь 1 399 412 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Чингис Хаан секюритиес ХХК 56 870 ширхэг хувьцааны саналаар /захирал/

1 945 050 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 73,3 % хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Хурлыг: Т.Зоригтбаатар удирдав.

Хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг уншиж танилцуулав.

Хурлаар:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт
2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт
3. Санхүүгийн тайланд хийсэн Аудитийн дүгнэлт.
4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах

5. Төслийн санхүүжилтийн тухай
6. ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай
7. Бусад

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга З.Туяа ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 73,3 % байгаа тул Монгол улсын компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэв.

Хурал 13 цаг 00 минутанд эхлэв.

Хурлын дарга Т.Зоригтбаатар : Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, ТУЗ-ийн дүгнэлтүүдийг уншиж танилцуулав. Мөн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт болон ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрүүдийг танилцуулав.

Компанийн хашаанд баригдах үйлдвэрлэл үйлчилгээ, орон сууцны барилгыг эхлэх тухай, мөн санхүүжилтийн талаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлуудыг танилцуулж санал авах нь зүйтэй гэж үзсэн учираас төслийн санхүүжилтын талаар танилцуулав.

Ингээд санал асуулт эхлэв.

З.Номундарь: Энэ жил эхлэхээр төлөвлөж байсан барилга бүтээн байгуулалтын ажил хөрөнгө оруулагчид корона вирусын халдварын улмаас Улаанбаатарт ирэх боломжгүйтэй холбоотойгоор хойшлогдсон байгаа. Хэдийгээр хөрөнгө оруулагчид ирээгүй мөн хэзээ хорио цээр тавигдах нь тодорхойгүй учир гадны улсаас бага хүүтэй зээл авах, дотоодоос хөрөнгө оруулагч хайх зэрэг ажлуудыг хийж байна. Тиймээс Санхүүжилт олж, гэрээ хийх эрхийг ТУЗ-д өгөх дээр тохиролцох хэрэгтэй байна.

Үүнд хувьцаа эзэмшигч та бүхний санал хүсэлт хэрэгтэй байна. Ингээд та бүхэн энэ асуудалд ач холбогдол өгч санал хүсэлтээ хуваалцана уу?

Л.Гүндэгмаа: Бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дэмжиж байгаа. Ботаникт шинэ эмнэлэг баригдсантай холбоотой энэ чиглэлд эмнэлгийн эмч багш ажилчдын шилжилт хөдөлгөөн ихсэж болзошгүй. Тиймээс сургууль цэцэрлэг хүүхдийн тоглох талбайтай хотхоныг зайлшгүй сонгоно. Тэр талыг нь сайн анхаарч ажиллавал борлуулалт сайн байна байхаа.

Т.Эрдэнэбаатар: Зөвөө, одоо энэ төслөө хурдан эхлүүлэх хэрэгтэй. Ямар арга зам байна, түүгээр нь шийдээд барилга байгууламжаа эхлэх хэрэгтэй байна.

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжинэ байх гэж бодож байна. Удирдлагын түвшинд шийдээд эхлүүлэх нь зүйтэй.

Л.Гүндэгмаа: Ялангуяа үйлдвэрлэл үйлчилгээний барилгаа эхлээд барьчих хэрэгтэй. Газрын төлбөр нэмэгдснээс үүдэн маш алдагдалтай ажиллаж байгаа яаралтай төслөө эхлэх эсвэл үйлчилгээний барилгуудаа яаралтай барьж эхлэл хэрэгтэй.

ХУРЛЫН ДАРГА



ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

Т.ЗОРИГТБААТАР

Ш.Наранхүү